

## СОР КАШЕМИР ХХК-НИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.02. 23

Улаанбаатар хот

### 1. Төслийн товч танилцуулга:

Сор Кашемир ХХК-нь 1998 онд анх түүхий эд бэлтгэл, гадаад дотоод худалдаа, хялгас самнах үйлдвэрлэл явуулах зорилготойгоор байгуулагдсан. Энэ цаг үеэс Монголын үйлдвэрлэл хөдөө аж ахуйн салбарт анх хөл тавьж ноолуур, сарлагийн хөөвөр, тэмээний ноос зэрэг малчдын амжиргааны гол түүхий эдийг орон нутгийн зах зээлээс худалдан авч үйлдвэрлэл явуулж улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж ирлээ. Өдгөө тус компанид ноос ноолуур ангилан ялгах цех, ноолуур самнах цех, будах цех, ноос ноолууран утас ээрэх цех, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех ажиллаж анхан шатны түүхий эдийг эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгох бүх шатны боловсруулалтыг гүйцэтгэж байна.

Монгол ямааны ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөөр хамгийн сүүлийн үеийн техник, технологиор үйлдвэрлэл явуулдаг. Бид өнгөрсөн хугацааны турш нэг сэтгэлээр тууштай ажиллаж өдөр өдрөөр өргөжин тэлж байгаа үндэсний шилдэг үйлдвэрлэгчдийн нэг билээ.

Манай компани нь өнөөдөр 110 хүнийг тогтмол ажлын байраар 20-30 орчим хүнийг ангилан ялгагчаар улирлын чанартай ажиллуулж, жилдээ 300-550 тонн ноолуур, 200 орчим тонн тэмээний ноос, 30 гаруй тонн сарлагийн хөөвөр, 200 гаруй тонн хонины ноосонд боловсруулалт хийж 100% хольцгүй цэвэр утас, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Өнөөдөр манай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүхий эд нь дэлхийн 10 гаруй оронд экспортлогдож байгаа бөгөөд дотоодын 200 гаруй сүлжих цехүүдтэй хамран ажиллаж ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөн ээрмэл утсаар хангаж байна. Сүлжмэл бэлэн бүтээгдэхүүнийг дэлхийн 10 гаруй оронд экспортлож байна.

### 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт:

Төслийн талбай нь 0,99 га талбайг эзлэн оршдог бөгөөд орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 1000 метрийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлий эрүүл ахуйнхамгаалалтын өүсийн хэмжээ, ерөнхий шаардлага,” MNS5105: 2001 стандартын шаардлагыг хангаж байна.

Нийгэм эдийн засаг: Баянгол дүүрэг нь 1992 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу тухайн үеийн Октябрийн районоос өрх тусгаарласнаар эхэлдэг. Монгол УИХ-ын 1992 оны 18 дугаар тогтоолын дагуу Баянгол дүүргийн ИТХ 100 төлөөлөгчтэйгээр анхны хуралдаанаа хийж Баянгол дүүргийг байгуулах тухай тогтоолыг 1992 оны 10 сарын 01ний өдөр гаргаснаар тус дүүрэг албан ёсоор байгуулагдсан. Тус хороо нь 1951 онд Октябрийн районы ОСГ-ын 4 дүгээр хороо нэртэйгээр байгуулагдаж анхны даргаар Тулга гэж хүн ажиллаж байжээ. 1992 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр Баянгол дүүргийн 20 дугаар хороо болон өөрчлөгдсөн. Нийгэм эдийн засгийн үйл ажиллагаандаа Нийслэл, дүүрэг, хорооны Засаг дарга нарын дэд хөтөлбөрүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэл явуулдаг аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах, тэднийг дэмжих, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр ажилладаг. Үйлдвэрлэл болон ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотойгоор нийт 17 орчим хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг.

### 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн чиглэлээр: 1. Агаар орчны чиглээр, 2. Дуу чимээ, 3. Хөрсөн бүрхэвч 4. Гадаргын доорх усны асуудал зэрэг 4 төрлөөр сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх, тэдгээртэй холбогдох хууль дүрэм, журмуудыг хэрэгжүүлэх зорилготой.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчлан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян,төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян,төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам стандарт
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	<b>1.Агаар орчны чиглэлээр:</b> Агуулах болон ноолууран утас ээрэх, сүлжих үйлдвэрийн хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын ууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавих	үйлдвэрт	ш	500,0	2	1000,0	2 улиралд	MNS0012-013:1991. ажлын байрны агаар, ажлын байрны агаарын бүс
2		Агуулахын тоосжилт, чимээ шуугиан, чийгшил, гэрэлтүүлгийн байдлыг сайжруулах	агуулахад	ш	18,0	30	540,0	1 улиралд	MNS17.2.3.16-88 “Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам”
3		Орчны болон ажлын байрны агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх /жилд 1 удаа/	үйлдвэрт	АБ-ны тоог оор	70,0	2	140,0	2 улиралд	УСТ3384-82” агаар мандлын сорьц авахад тавих еранхий шаардлага
1	<b>2.Дуу чимээ</b> Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Ажилтнуудыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	ажилтнууд	ш	5,0	65	1300,0	4 удаа	MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм-түвшний хэмжээ MNS 5002:2000
3		Дуу шуугианы хэмжилт /1цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар/ хийх	Үйлдвэрийн газар дотор болон гаднах талбайд	ш	30,0	3 цэг	90,0	1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй шуугианы норм, аюулгүй

									ажиллагааны ерөнхий шаардлага
1	3.Хөрсөн бүрхэвчийн асуудлаар. Химийн бодисын сан_амсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ахиж зайлалуулахгүй байх зэрэг нь хөрсийг бохирдуулна.	-Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах -Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах -Хүнсний сода, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгах	Агуулах орчимд	ш	100,0	1	500,0	1 удаа	MNS 3307:1991, MNS 3308:1991 хөрс, хөрсний элментүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 хөрс бохирдуулагч бодис, элментүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
1	4.Гадаргын доорх усны асуудал: Төслийн явцад усыг их хэмжээгээр замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	М³	2470	1	4000,0	12 удаа	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, -Усны тухай хууль
<b>Нийт</b>							<b>707,488</b>		<b>7570,0</b>

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян,төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам стандарт
0	1	2	3	4	5	6	7	8
1	Төслийн орчинд ногоон байгууламж бий болгох	Нийт ашиглалтын талбайн хойд захаар 15ш хайлаас, 20ш шинэс замын хажуугаар тарих	Ш	35	6000	210,0	5,6,7,8,9 саруудад	байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт, MNS5914:2008, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт MNS5916:2008, эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага MNS5918:2023
2	Ногоон байгууламжид арчилгаа тордлогоо хийх	Төсөл хэрэгжих орчинд ногоон байгууламжийн усалгаа, тайралт, хэлбэржүүлэлт хийх	мкв	60	60,0	500,0	Сүүлийн хагс жилд	
<b>Нийт</b>						<b>66,0</b>	<b>710,0</b>	

## 7. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг /мян,төг /	Нийт зардал /мян,төг /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах журам стандарт хууль
0	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйлсээс болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан тухай бүрд нь шинэчилж байх	Үйлдвэрийн хэмжээнд	1	200,0	500,0	жилдээ	---
2		Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах /амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гар унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт/	Үйлдвэрийн хэмжээнд	10	28,0	280,0	1 удаа	MNS8 5566:2005 аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
3		Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	Үйлдвэрийн хэмжээнд	1	100,0	300,0	1 удаа	MNS5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай
4	Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортиого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах	Үйлдвэрийн хэмжээнд	1	350,0	500,0	жилдээ	MNS 6458:2014 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах
5		Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сода, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах	Үйлдвэрийн хэмжээнд	1	--	Хөрсөн бүрхэвч дээр тусгасан	жилдээ	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл /M808/
<b>Нийт</b>					<b>670,0</b>	<b>1580,0</b>		

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	ахуйн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх	Үйлдвэрийн хэмжээнд	тн	4350	65	300,0	жилдээ	
2		Ангилан ялгаж тус тусад нь савтай болгох		ш	98,0	3	294,0	жилдээ	
3	Үйлдвэрийн	Аж ахуй нэгж байгууллагад нийлүүлэх /хүргэж өгөх/	Дахин боловсруулах аж ахуй нэгжүүд	тн	100,0	5	500,0	Тухай бүр	
<b>Нийт</b>					<b>202,350</b>		<b>1094,0</b>		

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
0	1	2	3	4	5	6	7	8
1	<b>1. Агаарын чанарын чиглэлээр:</b> Агаарын бохирдлын /NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> CO <sub>2</sub> тоос / шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэр дотроо	Агаарын найрлага жил бүрийн 4 сард	1	40,0	200,0	Шинжээч ийн цалин 97,0*2	- MNS4585:2016 агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, - MNS3384:1982 сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS4048:1988 тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS0017-2-5-11:1988 агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм, түвшний
2	Дуу шуугиан чичиргээ	Үйлдвэр дотроо	жил бүрийн 4 сард	1	30,0	150,0	Унааны зардал 30,0	
1	<b>2.Хөрсний бохирдлын чиглэлээр:</b> Хөрсний морфологи бичиглэл, PH,	Төслийн талбайд 1	Жил бүрийн 6 сард	1	45,0	45,0	ХНҮЭлгээний тайлан	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс, Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

	цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент / NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O/, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	цэг сонгох	/хөрсний химийн шинжилгэ э, хүнд металын шинжилгэ э тус бүр/				боловсруулах 250,0	- MNS 3309:1991 Хөрс, Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, - MNS 3298:1991 Хөрс, шинжилгээнд авахад тавих ерөнхий шаардлага - MNS ISO 11017:2001 Хөрсний чанар, Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох, Дөлийн болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
1	<b>3. Усан орчны чиглэлээр:</b> Үйлдвэрийн хаягдал усанд сар бүр шинжилгээ хийлгах	Үйдвэр дотор	жилдээ	1	60,0	60,0	Сар бүр хийлгэх шаардлагагүй	-----
<b>Нийт</b>					<b>175,0</b>	<b>869,0,0</b>		

#### 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2024 он			Хариуцсан албан тушаалтан	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
			сар	сар	сар		
0	1	2	3	4	5	6	7
1	Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	7570,0	2,3	4,5	6,7,8	Д.Батцэнгэл	Компанийн дотоод журмаар
3	Ажилтнуудад жилд 1 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах	төлөвлөгдөөгүй		04		Д.Батцэнгэл	
4	Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогмол зохион байгуулж байх	төлөвлөгдөөгүй	04			Д.Батцэнгэл	
5	Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	6000,0	03			Д.Батцэнгэл	
6	Ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	198,0	02	03		Д.Батцэнгэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
7	Ажлын байрны аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтууртай болгох	300,0		08		Д.Батцэнгэл	
10	Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан ажлын байрандаа ажилтнуудыг аарц, чацаргана, бээлий маскаар хангах	Цар тахлын нөхцөл үүссэн тохиолдолд тухай бүрт				Д.Батцэнгэл	

